# ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНААС 2018 ОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| д/д | Хэлэлцүүлэх асуудал | Хариуцсан нэгж | Хамтран ажиллах нэгж | Хугацаа, улирал | | | | Хэрэгжилт | Биелэлт /Хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I | II | III | IV | | |
| **Хэлэлцүүлсэн** | | | | | | | | | |
| 1. | Бүгд Найрамдах Мальт Улсын Засгийн газартай агаарын харилцааны хэлэлцээрийг байгуулах тухай | БТГ | АТБХЗХ | + | | | | Хэлэлцээрийг батлуулахаар Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналын хамт ЗГХЭГ-т 2018.03.02-ны 01/916 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. | 100 |
| 2. | Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газартай агаарын харилцааны хэлэлцээрийг байгуулах тухай | БТГ | АТБХЗХ | + | | | | Хэлэлцээрийг батлуулахаар Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналын хамт ЗГХЭГ-т 2018.03.02-ны 01/916 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. | 100 |
| 3. | Люксембургийн Их вант Улсын Засгийн Улсын Засгийн газартай агаарын харилцааны хэлэлцээрийг байгуулах тухай | БТГ | АТБХЗХ | + | | | | Хэлэлцээрийг батлуулахаар Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналын хамт ЗГХЭГ-т 2018.03.02-ны 01/916 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. | 100 |
| 4. | “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг УИХ-аар соёрхон батлах тогтоолын төслийн тухай | АТБХЗГ | БТГ | + | | | | Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2018.01.10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн бариад байна. | 100 |
| 5. | Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журам батлах тухай | АТБХЗХ | БТГ | | + | | | “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай ерөнхий журам”-ын төсөлд яамдаас дахин санал авч ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэлэлцүүлэхээр хүргүүлсэн | | | | | | | | | | |
| 6. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай | АТБХЗГ | | + | | | | | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын стратегийн хэрэгжилтийг 21 аймаг, холбогдох яам агентлагуудаас авч нэгтгэн ЗГ-ын хуралдаанд танилцуулахаар 2018.03.13—ны өдрийн 01/1095 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| Хэлэлцүүлэх хугацаа хэтэрсэн | | | | | | | | | | |
| 7. | Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл | ТЗДТБХЗГ | БТГ<br>ТЗУГ | + | + | | | | Хуулийн төслийг урьдчилсан байдлаар боловсруулж, 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан эхний хуралдааныг 2017.06.19-нд хийж, гишүүдэд удирдамж чиг үүргийг танилцуулж, төлөвлөгөөний дагуу хугацаатай чиглэл өгсөн. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу судалгаа, дүгнэлт гаргаж байна. 2017 оны 3 дугаар улиралд Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүжилтийг батлуулж, шийдвэрлэсэн. Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх дэд ажлын хэсэг дүгнэлт гаргаад байна. Мөн хуулийн хэлэлцүүлгийг “ГТХЗНТ” УТҮГ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК-ууд дээр хийсэн. Хэлэлцүүлэг үргэлжилж байна. Хэлэлцүүлгээс гарсан санал, хүсэлтүүдийг хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөлдөө тусгахаар ажиллаж байна. 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Төмөр замын тээврийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг шинэчлэх сайдын тушаалын төслийг боловсруулж байна. | 30 |
| 8. | “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын статусыг өөрчлөн зохион байгуулах тухай | БТГ | АТБХЗХ | + | | | | | Төслийг боловсруулж Засгийн газрын гишүүдээс санал авахаар бэлтгэж байна. | 30 |
| 9. | Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Камбожийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах тухай | БТГ | АТБХЗХ | + | | | | | Төслийг боловсруулж Засгийн газрын гишүүдээс санал авахаар бэлтгэж байна. | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10. | Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах тухай | БТГ | АТБХЗХ | + | | | | Төслийг боловсруулж Засгийн газрын гишүүдээс санал авахаар бэлтгэж байна. | 30 |
| 11. | Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээрийн “Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-т нэгдэн орох тухай УИХ-ын тогтоолын төсөл | БТГ | АТБХЗХ | + | | | | УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжигдсэн ба тус өдрийн 5 дугаар тэмдэглэлд Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-т олон талт хэлэлцээрийг дэмжиж, Засгийн газарт нэгдэн орохыг зөвшөөрсөн. Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-т нэгдэн орох, соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Сангийн яам, ХЗДХЯ, ГХЯ-д тус тус хүргүүлсэн. /2017.09.12-ны 01/4015 тоот/ Мөн хэлэлцээрийн орчуулгыг дахин хянуулж, баталгаажуулахаар ГХЯ-д /2017.09.12-ны 01/4014 тоот/ хүргүүлсэн.<br>Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлөг худалдах хэлэлцээр”-ийн монгол хэл дээрх орчуулгыг Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулахаар хүргүүлэхээр бэлтгэсэн, албан тоотыг албажуулах шатанд байна. | 30 |
| 12. | “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр” батлах тухай | БТГ | АТБХЗХ | + | | | | “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хавсралт баримт бичгүүдийг Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу бэлтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн сайдад 2017.09.21-ний 01/4164 тоотоор, ЗГХЭГ-т 2017.09.21-ний 01/4165 тоотоор тус тус хүргүүлээд байна. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдаж байгаа тул шинээр бүрэлдэх засгийн газарт танилцуулах гэсэн шалтгаанаар ЗГХЭГ-аас 2017.10.18-ны өдрийн ХЭГ/1504 тоот албан бичгээр буцаасан. Дахин хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төсөлд Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг тусган бэлтгэсэн, Сангийн сайдаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авах бэлтгэл ажлын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, тооцоо судалгаа эцэслэн гаргахыг хүлээж байна. Тооцоо судалгааг Иргэний нисэхийн ерөнхий газрын хэмжээнд, Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчдийн холбоотой хамтран хийж байна. | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн тухай | АТБХЗГ | БТГ | + | | | | Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги"-г шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. Уг ажил 2018 оны 04 дүгээр сард дуусна. | 30 |
| **Хэлэлцүүлэх хугацаа болоогүй** | | | | | | | | | |
| 14. | Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл | АТБХЗГ | БТГ<br>ТЗУГ | | + | + | | Автотээврийн тухай хуулийн үзэл баримтлалд нэмэлт, өөрчлөлт хийж боловсруулан 2016.10.27-ны 01/1366 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, хамтран баталсан. Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт автотээврийн салбарт ажил үйлчилгээ эрхэлдэг 54 аж ахуйн нэгжийн 120 гаруй төлөөлөгчид оролцсон.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2017.03.31-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлж, гишүүдээс өгсөн саналыг тусган бүх яамдаас санал авч нэгтгэсэн. Автотээврийн тухай хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2017.04.17-ны өдрийн 01/1548 тоотоор хүргүүлсэн ба Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн хуулийн төслийг эцэслэн боловсруулж байна.<br>Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу өргөн барихад шаардагдах зардлын тооцоо, судалгаа, хуулийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн судалгааг хийж байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийг өргөн барихад дагалдах судалгаа, хуулийг хэрэгжүүлснээр гарах үр ашиг, зардлын тооцоог "СИВИКО" консалтинг компани гүйцэтгэсэн. Зөвлөх үйлчилгээний баг гэрээний дагуу хийсэн ажлаа хүлээлгэн өгсөн. 2018.01.09-ний өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. Сайдаас хуулийн төслийг сайтар хянан үзэж чиглэл өгөхөөр болсны дагуу сайдын орон тооны бус зөвлөхөд хуулийн төсөл, дагалдах судалгаа, шинжилгээний материалуудыг өгсөн. Зөвлөхөөс тодорхой санал, дүгнэлтийг гарган ирүүлсэний дагуу Хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран батлахаар ХЗДХСайдад 2018.03.06-ны өдрийн 01/949 тоот албан бичгээр хүргүүлээд байна. | 70 |
| 15. | Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл | БТГ | АТБХЗХ<br>ТЗУГ | | + | + | | "Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-ийн хувьд уг ажлыг зохион байгуулах Ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд салбарын хэмжээнд 2017.05.19-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт ЗТХЯ, Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба, Иргэний нисэхийн ерөнхий газар, Агаарын тээврийн компаниуд, Онцгой байдлын ерөнхий газрын төлөөллүүд оролцсон. Хэлэлцүүлэгт оролцогсдын саналыг бичгээр авч шинэчилсэн найруулгын төсөлд тусгасны дараагаар шинэчилсэн төслийг дахин хэлэлцэх хүсэлтийг оролцсон байгууллага, | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэргэжилтнүүдээс ирүүлснийг харгалзан үзэж, “Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна. Иргэний нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж тайланг ирүүлэх талаар ЗТХЯ-ны 2017.09.21-ний өдрийн 05а/4167 тоот албан бичгээр ИНЕГ-т мэдэгдсэн.<br>ЗТХСайдын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 33 дугаар тушаалаар Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлдэх ажлын хэсэг байгуулагдаж, 2018.03.13-ны өдрийн 15.00 цагт эхний хурлаа хийсэн. | |
| 16. | Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл | БТГ | ТЗДТБХЗГ | | + | | | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 118 дугаар тушаалаар “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. ХШҮДАГ-аас "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланд тус бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй, шинэчлэн боловсруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан бөгөөд 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдөр ажлын хэсэг хуралдаж, ажлын төлөвлөгөө болон ажлын хэсгийн зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн төслийг авч хэлэлцсэн. Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой санхүүжилтийг шийдвэрлэсэн. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тандан судалгаа, нөлөөллийн шинжилгээ хийж, эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулж байна. 2 дугаар улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | 30 |
| 17. | “Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн тухай | АТБХЗГ | БТГ | | + | | | Сайдын зөвлөлийн хурлаар 2018.01.09-ний өдрийн хуралд танилцуулсан. Хуулийн төсөлтэй уялдуулж дахин боловсруулж танилцуулах үүрэг өгсөн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу холбогдох тандан судалгаа, нөлөөллийн шинжилгээг хийж байна. Нийт 4 хэлэлцүүлэг хийхээр төлөвлөснөөс нэг удаагийн хэлэлцүүлгийг Автотээврийн удирдах ажилтны зөвлөгөөний үеэр хэлэлцүүлсэн. Засгийн газрын 249 дүгээр тогтоолоор батлагдсан Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах журмын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж байна. | 30 |
| 18. | “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ | БТГ | АТБХЗХ | | + | | | Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанд “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концесс олгох тухай асуудлыг | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концесс олгох тухай | | | | | | | танилцуулсан бөгөөд төслийг хэрэгжүүлэх этгээдтэй байгуулах гэрээний төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг ЗТХЯ, ҮХГ-т даалгасан. ЗТХЯ-ны 2018.01.26-ны өдрийн 03/413 тоот албан бичгээр Концессийн гэрээний төсөлд санал авахаар ХЗДХЯ-д хүргүүлсэн. | |
| 19. | Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Азербайджан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах | БТГ | АТБХЗХ | | + | | | Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Азербайджан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулж байна. | 30 |
| 20. | Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн тухай | АТБХЗХ | БТГ | | + | | | ИНЕГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 01/4310 тоот албан бичгээр ирүүлсэн уг хөтөлбөрийн төслийг хянаж ЗТХЯ-ны 2018.02.06-ны өдрийн 09/582 тоот албан бичгээр буцаасан. ИНЕГ-аас 2018.02.15-ны өдрийн 01/545 тоот албан бичгээр тус хөтөлбөрийн төсөлд нэмэлтээр тусгах шаардлагатай санал, зөвлөмжийг тусгасан ирүүлснийг дахин хянан боловсруулж ЗТХЯ-ны удирдлагад танилцуулах бэлтгэл хангагдсан болно. | 30 |
| 21. | “Тусгай зориулалттай авто замыг барих-засварлах-ашиглах журам”-ын тухай | АЗБХЗГ | БТГ | | + | | | “Тусгай зориулалтын авто замыг барих, ашиглах, засвар арчлалт хийх тухай” журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 191 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс “Тусгай зориулалтын авто замыг барих, ашиглах, засвар арчлалт хийх тухай” журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, журмын төслийг боловсруулсан. | 30 |
| 22. | Орон нутагт тээврийн алба байгуулах тухай | АТБХЗГ | БТГ | | + | | | Орон нутагт тээврийн алба байгуулах талаар 21 аймгийн Засаг дарга нараас санал авч байна. Одоогийн байдлаар 10 аймгийн Засаг дарга саналаа ирүүлсэн бөгөөд ЗГ-ын шийдвэрийн төслийг бэлтгээд байна. Хугацаа болоогүй. | 30 |
| 23. | Барааг түр хугацаагаар нэвтрүүлэх тухай Станбулын конвенцийн CPD карней олгох тухай | АТБХЗГ | БТГ | | + | | | Барааг түр хугацаагаар нэвтрүүлэх тухай конвенцийн 1 дүгээр зүйлд заасны дагуу CPD карней олгох, баталгаа гаргах чиг үүргийг гүйцэтгэх байгууллагад зөвшөөрөл хүссэн тухай 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 07/129 тоот албан бичгийг Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Хариу хүлээгдэж байна. | 30 |
| 24. | Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн | ТЗДТБХЗГ | БТГ<br>ТЗУГ | | + | + | | Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж байна. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тухайн хуулийн шинэчилсэн найруулгыг | 30 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үзэл баримтлал, хуулийн төсөл | | | | | | | хийх шаардлагатай эсэх талаар урьдчилсан судалгаа хийж ирүүлэх даалгаврыг Далайн захиргаанд 2017.05.09-ний өдрийн 04/1991 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч одоог хүртэл ирүүлээгүй байна. Холбогдох судалгааг яаралтай ирүүлэх үүргийг 2017.06.15-ны өдөр хуралдсан Сайдын шуурхай дээр өгөв. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг шинэчлэх тушаалын төсөлд санал авч байна. Далай ашиглах тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 27 дугаар тушаалаар байгуулсан. 2018 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 14 цагт Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоотод ажлын хэсэг хуралдахаар төлөвлөж байна. | |
| 25. | “Төрөөс авто замын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн тухай | АЗБХЗГ | БТГ | | | + | | Төрөөс авто замын салбарт баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 59 дүгээр ТНБД-ын тушаалаар байгуулсан. Уг баримт бичгийн бодлогын судалгааны ажлыг ННС-ын хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөж, ажлын даалгавар боловсруулан Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийг боловсронгуй болгох сангаас санхүүжилтийг шийдвэрлэж тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зөвлөх үйлчилгээний “Хязгааргүй хөдөлгөөн” ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу уг ажлыг 2018 оны 3 дугаар сарын 30-ны дотор гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө. Энэхүү судалгааны ажлын эхлэлийн тайлангийн санхүүжилтийг олгоод байна. | 30 |
| 26. | Орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулахад татаас олгох, татварын бодлогоор дэмжих тухай | АТБХЗХ | БТГ | | | + | | “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр” батлуулсны дараагаар шийдвэрлэнэ. | 0 |
| 27. | Автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар Европын холбооны зарим улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах тухай | АТБХЗГ | БТГ | | | + | | Бүгд Найрамдах Чех Улсаас ирүүлсэн хэлэлцээрийн төслийг судлан үзээд хариу саналаа хүргүүлж, ГХЯ-нд орчуулга хийгдэж байна. Монгол Улсын Ерөнхий сайд Турк, Чех Улсад айлчлах үеэр тус хэлэлцээрийг байгуулах саналыг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.<br>Унгар болон Литва улсаас “Автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр-” байгуулахаар ирүүлсэн хэлэлцээрийн төслийг орчуулах ажил хийгдэж байна. | 30 |
| 28. | Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичигт нэмэлт оруулах | БТГ | АТБХЗХ | | | | + | Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хариуцан гүйцэтгэх Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2018.01.24-ний өдрийн 14 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нь “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 2 заалтад өөрчлөлт оруулах | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай УИХ-ын тогтоолын төсөл | | | | | | | төсөл, УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, холбогдох баримт бичгийн бүрдлийн хамт Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. Нэмэлт өөрчлөлт оруулах заалтын төслийг яам, ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулан 2018.03.26-ний өдрийг дуустал хугацаанд олон нийтээс санал авч байна. | |
| 29. | “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-т нэмэлт өөрчлөлт оруулах тухай | АТБХЗХ | БТГ | | | | + | Энэ ажлын хүрээнд тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д заасны дагуу конвенцийн хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь үндсэн олон улсын гэрээний гол нөхцөлийг хөндөөгүй техникийн шинжтэйг тогтоолгохоор гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандахаар төлөвлөж байна. Иймд конвенцийн 9, 17 дугаар хавсралтуудад оруулсан хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлтүүдийг англи, монгол хэл дээр, танилцуулгын хамт энэ оны 10 дугаар сарын 05-ны дотор, хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж, шинэчлэн боловсруулсан хөтөлбөрүүдийн төслийг, танилцуулгын хамт энэ оны 10 дугаар сарын 25-ны дотор тус тус ирүүлэх шаардлагатай тухай ЗТХЯ-ны 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 09-4179 тоот албан бичгээр ИНЕГ-т мэдэгдээд байна. | 30 |
| 30. | “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | АТБХЗХ | БТГ | | | | + | Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4-д заасны дагуу конвенцийн хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлуулахаар ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д заасны дагуу конвенцийн хавсралтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь үндсэн олон улсын гэрээний гол нөхцөлийг хөндөөгүй техникийн шинжтэйг тогтоолгохоор гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандахаар төлөвлөж байна. Иймд конвенцийн 9,17 дугаар хавсралтуудад оруулсан хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлтүүдийг англи, монгол хэл дээр, танилцуулгын хамт энэ оны 10 дугаар сарын 05-ны дотор, хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж, шинэчлэн боловсруулсан хөтөлбөрүүдийн төслийг, танилцуулгын хамт энэ оны 10 дугаар сарын 25-ны дотор тус тус ирүүлэх шаардлагатай тухай ЗТХЯ-ны 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 09-4179 тоот албан бичгээр ИНЕГ-т мэдэгдээд байна. | 30 |
| 31. | Хөлөг онгоц бүртгэх журмын шинэчилсэн найруулгын төслийг батлах тухай | ТЗДТБХЗГ | БТГ | | | | + | Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулсны дараа “Хөлөг онгоц бүртгэх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг тус хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | 0 |
| 32. | Унадаг дугуйг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн тухай | БТГ | АТБХЗГ | | | | + | Судалгааны ажил гүйцэтгэгч “Монголын авто замчин залуучуудын холбоо”-оос ирүүлсэн эхний шатны тайланг судлан үзэж, шаардлага хангахгүй байгаа талаар хариу өгсөн. | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33. | “Дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног, төхөөрөмж, эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай болон эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрт нэгдэн орох тухай | БТГ | АТБХЗГ | | | | + | Хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулж байна. | 30 |
| **Хэлэлцүүлэх шаардлагагүй болсон** | | | | | | | | | |
| 34. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл байгуулах тухай | АТБХЗГ | БТГ | + | | | | ЗХАБ-ын Үндэсний зөвлөл байгуулах талаар ЗГХЭГ-т 2 удаа бичиг явуулсан бөгөөд ЗГХЭГ-ээс Үндэсний зөвлөл байгуулахгүйгээр Зам, тээврийн хөгжлийн сайд ахалсан Үндэсний хороог үргэлжлүүлэн ажиллуулах чиглэл өгсөн. | - |
| 35. | БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2 дугаар шатны тухай | АТБХЗГ | БТГ | | + | | | Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сан /”ЭЗХХАС”/-гаас 2011-2018 онд авах зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хоёрдугаар шатны төслөөр 25 сая.ам.долларын санхүүжилт бүхий төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Сангийн яам, БНСУ-ын Экспорт-импорт банкны хооронд зээлийн гэрээг 2016 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан. Энэхүү хэлэлцээрт өөрчлөлт оруулан автобусны үйлдвэрлэлийн шугам байгуулах гэрээг шинэчлэх асуудлаар Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаас үүрэг өгсөн. Сангийн яам 2017 оны 02 дугаар сарын 08-ний 10-1/814 тоот албан бичгээр Солонгосын талд хүсэлт явуулав. БНСУ-ын ЭКСИМ банкнаас 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн MON-11/17-133 тоот албан бичгээр хэлэлцээр, гэрээнд өөрчлөлт оруулах боломжгүй тухай татгалзсан хариуг ирүүлсэн тул гэрээний дагуу төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | - |

---oOo---